

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 100 ЖИЛИЙН ОЙ,
МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ГИШҮҮНЭЭР
ЭЛССЭНИЙ 50 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ИРЭЭДҮЙН АЖИЛ, МЭРГЭЖИЛ”
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Орчин үеийн аж үйлдвэр, техник технологийн хурдацтай хөгжил дэвшил, эдийн засгийн глобальчлал, орон зай, цаг хугацааны шийдэл, цаг уурын өөрчлөлт зэрэг нийгэм, эдийн засгийн хувьслыг даган, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага хурдтайгаар өөрчлөгдөж байна. Энэхүү өөрчлөлтийн хүрээнд нэг талаас хөдөлмөрийн зах зээлийн зарим ажил, мэргэжлийн хэрэгцээ багасах, өрсөлдөх чадвар буурах, бүр устан алга болж байгаа бол нөгөө талаас шинэ ажил мэргэжил бий болж, хэрэгцээ шаардлага нь нэмэгдэж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага болон дэлхийн улс орнууд дээрх асуудалд анхаарал хандуулж, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, хэтийн төлөвлөлтдөө “ИРЭЭДҮЙН АЖИЛ, МЭРГЭЖИЛ”-ийг зохистой хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд бүтээмжтэй, хангалттай орлоготой, тогтвортой хөгжих боломж, бололцоог эрэлхийлэх үүднээс бодлогоо тодорхойлохыг эрмэлзэж байна.

ЗОРИЛГО

Эрдэм шинжилгээний хурлын зорилго нь хөдөлмөрийн зах зээл болон бусад холбогдох асуудлаар эрдмийн ажил хийж буй оюутан, залуучуудын судалгааны ажлыг дэмжих, аргагүйг хэлэлцүүлэх, бүтээлийг нь олон нийтэд түгээн танилцуулах замаар хөдөлмөрийн хүрээний ойлголт, мэдлэгийг сурталчлан дэлгэрүүлэхэд оршино.

СЭДВИЙН ЧИГЛЭЛ

Бүтээл нь “ИРЭЭДҮЙН АЖИЛ, МЭРГЭЖИЛ” ерөнхий сэдвийн дор хөдөлмөрийн зах зээлийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсон, дараах агуулгыг илэрхийлсэн судалгаа, шинжилгээний ажил байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн ирээдүйн чиг хандлагын талаар;
- ✓ Ирээдүйд шинээр буй болох болон хэрэгцээгүй болох тодорхой ажил мэргэжлийн талаар;
- ✓ Ирээдүйн ажлын байр, түүний нөхцлийн өөрчлөлт, шинэчлэлт;
- ✓ Ажиллагчдад тавигдах ур чадвар, түүний өөрчлөлт, хандлага;
- ✓ Техник технологи нь хүний хөдөлмөрийг орлох талаар;
- ✓ Техник технологи өөрчлөлт болон хөдөлмөрийн бүтээмжийн хамаарал.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэ хичээлийн жилд их, дээд сургуульд суралцаж буй магистр, бакалаврын ангийн нийт оюутнуудын дунд нээлттэй зохион байгуулна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Бүтээл нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ✓ Онол, арга зүйн үндэслэлтэй байх;

- ✓ Тодорхой тоон болон чанарын мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан байх;
- ✓ Шинжилгээний арга зүй ашигласан байх;
- ✓ Эрдэм шинжилгээний бүтээлд Олон улсад мөрдөгдөж буй арга зүй, туршлагыг судалж, ашигласан бол давуу тал болно;
- ✓ Ишлэл, зүүлтийг стандартын дагуу хийсэн байх;
- ✓ Бусдын бүтээлийг хуулбарлаагүй байх;
- ✓ Ашигласан материалын жагсаалт гаргах, цахим хаяг тохиолдолд холбоосыг оруулсан байх;
- ✓ Бүтээл нь хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, зөвлөмж, ашигласан материалын жагсаалтыг оролцуулан А4 (210x297mm) хэмжээтэй 15 хуудсанд багтсан байх;
- ✓ Үсгийн хэмжээ – ARIAL font – 12 байна;
- ✓ Математик, статистик томъёоллыг “Equation” ашиглан оруулах ба тэмдэгтийн хэмжээ 10pt, Bold, Italic;
- Мөр хоорондын зай 1,5 Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм байна.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Ерөнхий зохион байгуулагч:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага;
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо;
- Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо.

Хамтран зохион байгуулагч:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт;
- Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар.

ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ:

Эрдэм шинжилгээний хуралд оролцох бүтээлийг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 17:00 цаг хүртэл файл хэлбэрээр хүлээн авах бөгөөд шүүгчдийн бүрэлдэхүүн хоёрдугаар шатанд хэлэлцүүлэх найман бүтээлийг шалгаруулна.

Хоёрдугаар шатны хэлэлцүүлгийг 11 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 10 давхрын хурлын танхимд зохион байгуулж, эхний 3 байрыг шалгаруулна. Илтгэлийн үргэлжлэх хугацаа 15 минут байна.

ШАГНАЛЫН САН:

- 1 дүгээр байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 1 500 000 төгрөг;
- 2 дугаар байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 1 000 000 төгрөг;
- 3 дугаар байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 500 000 төгрөг.

БҮТЭЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн дараахь цахим хаягаар илгээнэ.

Зөвхөн шалгарсан бүтээлүүдийн эзэнтэй утас, и-мэйл хаягаар холбогдох тул холбоо барих өөрийн болон ойр дотны хүнийхээ утасны дугаарыг тодорхой бичиж ирүүлнэ.

Цахим хаяг: ilo50years@rilsp.gov.mn

Тодруулга авах утас: 77121286, 88079004

---oOo---